МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 20

ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ СУДАЛЖ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖЭЭ




Увс аймгийн прокурорын газраас тус аймгийн хэмжээн дэх эрүүгийн хэргийн нөхцөл байдлыг 2021 оны эхний гурван сарын байдлаар судлан дүн шинжилгээ хийжээ.

Дээрх хугацаанд аймгийн прокурорын газарт нийт 177 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд хяналт тавин ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.1 дахин өссөн байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн дийлэнх нь буюу 50.8 хувь нь Улаангом суманд бүртгэгдсэн бол Ховд, Зүүнхангай сумдад хамгийн бага бүртгэгджээ.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

✓ **Увс аймгийн прокурорын газраас тус аймгийн хэмжээн дэх эрүүгийн хэргийн нөхцөл байдлыг 2021 оны эхний гурван сарын байдлаар судлан дүн шинжилгээ хийжээ.**



Тус аймагт Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, Залилах, Мал хулгайлах гэмт хэргүүд зонхилон үйлдэгдсэн бөгөөд 26-35 насныхан гэмт хэрэгт ихээр холбогдсон байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд ахуйн хүрээнд ах, дүү, найз нөхдөөрөө архи согтууруулах үндааны зүйл хэтрүүлэн хэрэглэх, улмаар бусадтай таарамжгүй харьцах, хардалт, ялимгүй зүйлээс болж хэрүүл маргаан үүсэх, малчин иргэд малаа хариулгагүй орхих зэргээс болж гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймгийн прокурорын газраас дээрх судалгааны дүнг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан, тодорхой ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Мөн зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2855